



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар Б/23

Баян-Овоо сум

Ж.Цагаачинг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт (сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ), Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дэх заалт (шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай), 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээр тогтоол (төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам), Боловсролын сайдын 2026 оны 01 сарын 26-ны өдрийн А/20 тушаал (Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай)-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жигжидийн Цагаачинг математикийн багш дутагдалтай байгааг үндэслэн 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үүрэгт ажилд томилсугай.

2. Математикийн багш Ж.Цагаачингийн сарын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэлээр тогтоон 2,226,000 (хоёр сая хоёр зуун хорин зургаан мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар, кабинет лаборатори хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг 5 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг багш Ж.Цагаачинд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *Ч.Болормаа* Ч.БОЛОРМАА



0326010059